



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот


Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг нэгдүгээр, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хоёрдугаар, Хил хамгаалах байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг гуравдугаар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг дөрөвдүгээр, Улсын бүртгэлийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тавдугаар, Архивын байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг зургадугаар, Гадаадын иргэн, харьяатын байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг долдугаар, Дотоод хэргийн их сургуулийн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/70, 2019 оны А/195, 2020 оны А/143, А/171 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /Ж.Болд/, Хил хамгаалах ерөнхий газрын дарга /Х.Лхагвасүрэн/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /Д.Загджав/, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга /Д.Дэлгэрсайхан/, Архивын ерөнхий газрын дарга /С.Энхбаатар/, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Н.Ууганбаяр/, Дотоод хэргийн их сургуулийн захирал /П.Батбаатар/ нарт үүрэг болгосугай.



Doc:tushaal Said. 2021

151600147

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/20 дугаар тушаалын зургадугаар хэвсрэлт

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЛБАНЫ
НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

1119287523 ШТТ6740 9131817

д/д	Албаны нууцад хамаарах мэдээлэл
1.	Архивын баримтын Улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо
2.	Архивын ерөнхий газрын барилгын болон техникийн бүтцийн зураг
3.	Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч
4.	Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл
5.	Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан бичиг
6.	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
7.	Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж
8.	Байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай мэдээлэл
9.	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл
10.	Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр

---oOo---